



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/38

Булган сум

**Газар эзэмших эрх шилжүүлэх тухай**

Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Батчулуун (ГЭ50042711)-ны Булган сум 5 дугаар баг Агуулахын товог 1 дүгээр гудамж 109а тоотод байршилтай 6308003833 нэгж талбар бүхий гэр, орон сууц хашааны зориулалтаар эзэмшиж буй 40 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийг өв залгамжлагч Б.Уянга (ГЭ81041706)-д шилжүүлэн эзэмшүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2. Б.Уянгатай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2003 оны 116 дугаар захирамжийн Д.Батчулуунтай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6332011153